



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 413

Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны  
158 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт  
оруулах, шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 158 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ"-г энэ тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 158 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хадгаламж зээлийн хоршооноос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-ний 1.1-г заасан Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны үйлчилгээний хөлсний дээд хэмжээ “2,000,000 төгрөг” гэснийг “3,000,000 төгрөг” гэж өөрчлөн тогтоож, дор дурдсан утга агуулга бүхий 2.4, 2.5 гэсэн мөр нэмсүгэй.

“2.4. Хуримтлалын сангийн үйл ажиллагаа 100,000.00 төгрөг

2.5. Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа 100,000.00 төгрөг”

3. Улаанбаатараас бусад аймаг, сумдын нутаг дэвсгэрт байгуулагдаж, үйл ажиллагаа эрхлэж байгаа банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодыг 3 жилийн хугацаанд тогтоосон хэмжээгээр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөхөөс чөлөөлсүгэй.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-д даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001087



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН  
 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

	Зохицуулалттай үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа	
<b>НЭГ. Тусгай зөвшөөрөл</b>				
1.1	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа /Нийт активын дүнгээс өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг хассан дүн/	4,000,000,001.00 төгрөгөөс дээш бол	3,600,000.00 төгрөг	Жил бүр
		2,000,000,001.00-4,000,000,000.00 төгрөг хүртэл бол	3,000,000.00 төгрөг	Жил бүр
		1,000,000,001.00-2,000,000,000.00 төгрөг хүртэл бол	2,200,000.00 төгрөг	Жил бүр
		600,000,001.00-1,000,000,000.00 төгрөг хүртэл бол	1,600,000.00 төгрөг	Жил бүр
		400,000,001.00-600,000,000.00 төгрөг хүртэл бол	1,000,000.00 төгрөг	Жил бүр
		200,000,001.00-400,000,000.00 төгрөг хүртэл бол	800,000.00 төгрөг	Жил бүр
		100,000,001.00-200,000,000.00 төгрөг хүртэл бол	500,000.00 төгрөг	Жил бүр
		100,000,000.00 төгрөг хүртэл бол	350,000.00 төгрөг	Жил бүр
<b>ХОЁР. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ</b>				
2.1	Улаанбаатар хотод салбар нээх зөвшөөрөл	200,000.00 төгрөг	Тухай бүр	
2.2	Орон нутагт салбар нээх зөвшөөрөл	20,000.00 төгрөг	Тухай бүр	
2.3	Тусгай зөвшөөрлийг сэргээх	100,000.00 төгрөг	Тухай бүр	
2.4	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000.00 төгрөг	Тухай бүр	